

ИЛ ТОД БАЙДАЛ
(ТӨСВИЙН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ИНДЕКС)

51

Монгол Улсын Засгийн газар олон нийтэд төсвийн талаар зөвхөн зарим мэдээллийг өгдөг.

(НИЙТ 100 ОНООНООС)

**ИРГЭДИЙН
ОРОЛЦОО**

19

(НИЙТ 100 ОНООНООС)
Монгол Улсын Засгийн газар иргэдэд төсвийн үйл явцад оролцох боломж олгохдоо сул.

**ТӨСВИЙН
ХЯНАЛТ**

70

(НИЙТ 100 ОНООНООС)

**ХУУЛЬ ТОГТООХ
БАЙГУУЛЛАГА**
Монгол Улсын хууль тогтоох байгууллагын зүгээс төсөвт тавих хяналт хангалттай.

92

(НИЙТ 100 ОНООНООС)


АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
Монгол Улсын аудитын дээд байгууллагын зүгээс төсөвт тавих хяналт хангалттай.

ИЛ ТОД БАЙДАЛ (ТӨСВИЙН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ИНДЕКС)

Төсвийн нээлттэй байдлын судалгаа нь олон талт хамтын ажиллагааны байгууллагуудаас боловсруулан гаргаж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шалгуурт тулгуурласан 109 үзүүлэлтийг ашиглан төсвийн ил тод байдлыг тодорхойлдог. Эдгээр шалгуур үзүүлэлтээр тухайн улсын засгийн газраас олон нийтэд зориулан төсвийн найман гол баримт бичгийг цаг тухайд нь нийтэлсэн байдал, мөн эдгээр баримт бичигт багтсан мэдээллийн иж бүрэн болон ач холбогдолтой байдлыг үнэлдэг.


Улс тус бүрийг 100 хүртэлх оноогоор үнэлж, төсвийн нээлттэй байдлын цорын ганц хараат бус харьцуулалтын хэмжүүр болох Төсвийн нээлттэй байдлын индексээр эрэмбэлдэг.

Төсвийн мөчлөг дэх баримт бичгүүдэд агуулагдаж буй мэдээллийн ач холбогдлын түвшин




Жич: Бичиг баримт тус бүрийн ашиглаж болохуйц байдлыг дараах байдлаар ангилдаг: Боловсруулаагүй, Хожуу нийтэлсэн, Дотоод хэрэгцээнд, Өчүүхэн (0-20), Туйлын бага (21-40), Хязгаарлагдмал (41-60), Дорвитой (61-80), Бүрэн хэмжээнд (81-100).

Бүсийн хэмжээний харьцуулалт



Монгол Улс нийт авбал зохих 100 онооноос 51-ийг авсан нь дэлхийн дундаж (45 оноо)-аас ялимгүй дээгүүр байна.

Төсвийн ил тод байдлын өөрчлөлт, оноор



ИЛ ТОД БАЙДАЛ (ТӨСВИЙН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ИНДЕКС)

Төсвийн баримт бичгийг нийтэлсэн байдал, оноор

Баримт бичиг	2006	2008	2010	2012	2015
Төсвийн хүрээний мэдэгдэл	●	●	●	●	●
Гүйцэтгэх засаглалын төсвийн санал	●	●	●	●	●
Батлагдсан төсөв	●	●	●	●	●
Иргэдэд зориулсан төсөв	●	●	●	●	●
Жилийн явцын тайлангууд	●	●	●	●	●
Хагас жилийн тойм	●	●	●	●	●
Жилийн эцсийн тайлан	●	●	●	●	●
Аудитын тайлан	●	●	●	●	●

● Боловсруулаагүй/хожуу нийтэлсэн ● Дотоод хэрэгцээнд ● Нийтэлсэн

Монгол Улсын 2015 оны Төсвийн нээлттэй байдлын индекс 51 оноо байгаа нь 2012 онтой ижил үзүүлэлт юм.

Монгол Улсын Засгийн газар жил бүр төсвийн аль баримт бичгийг олон нийтэд ил тод болгох талаар тогтвортой бодлого баримталж байгаагүй байна.

2012 оноос хойш Засгийн газар дараах байдлаар төсвийн мэдээллийн хүртээмжийг сайжруулж ирсэн. Үүнд:

- Иргэдэд зориулсан төсвийг нийтэлсэн (батлагдсан төсвийн хувьд).
- Жилийн эцсийн тайлангийн иж бүрэн байдлыг сайжруулсан.

Гэвч Засгийн газар дараах чиглэлээр ахиц дэвшил гаргасангүй. Үүнд:

- Хагас жилийн тойм боловсруулаагүй.
- 2014 оны гүйцэтгэх засаглалын төсвийн төслийг бүрэн эхээр нь нийтлээгүй (Сангийн яам зөвхөн төсвийн тооцоолол бүхий хавсралтуудыг нийтэлсэн. Харин хууль тогтоох байгууллага төсвийн төслийг бүрэн эхээр нь нийтэлсэн.).


ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Олон улсын туршлагаас харахад засаглалыг сайжруулахад дан ганц төсвийн ил тод байдал хангалтгүй бөгөөд төсвийн үйл явцад иргэд оролцоноор төсвийн ил тод байдал хангагдаж гарах эерэг үр дүн нь нэмэгдэнэ. Төсвийн нээлттэй байдлын судалгааны хүрээнд иргэдийн оролцоог үнэлэхдээ засгийн газар нь төсвийн үйл явцад иргэдийн оролцох боломжийг ямар хэмжээнд олгодогээр тодорхойлдог. Ийм боломжийг гүйцэтгэх засаглал, хууль тогтоох болон аудитын дээд байгууллагын зүгээс төсвийн мөчлөгийн бүхий л шатанд олгох нь зүйтэй.

Иргэдийн оролцоо



Бүсийн хэмжээний харьцуулалт



Иргэдийн оролцооны хувьд Монгол Улс 100 онооноос 19-ийг авсан нь манай улсад төсвийн үйл явцад иргэд оролцох боломж сул байгааг харуулж байна. Энэ нь дэлхийн дундаж болох 25 онооноос доогуур үзүүлэлт юм.

ТӨСВИЙН ХЯНАЛТ

Төсвийн нээлттэй байдлын судалгаа нь хууль тогтоох хийгээд аудитын дээд байгууллагуудын зүгээс төсөвт хяналт тавьж буй байдлыг мөн үнэлдэг. Эдгээр байгууллага нь улсын төсвийг төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавихад чухал үүрэг гүйцэтгэдэг ба энэхүү үүргийг үндсэн хуулиар баталгаажуулах нь түгээмэл байна.

Хууль тогтоох байгууллагын хяналт

Төлөвлөлтийн үе шатанд



Хангалттай

Хэрэгжилтийн үе шатанд



Хязгаарлагдмал

Хууль тогтоох байгууллагын зүгээс төсөвт тавих хяналт нь төсвийн мөчлөгийн төлөвлөлтийн үе шатанд **хангалттай**, харин хэрэгжилтийн үе шатанд **хязгаарлагдмал** байна. Хуулийн дагуу ч, бодит амьдрал дээр ч төлөвлөснөөс илүү орлого болон нөөц сангийн хөрөнгийг хууль тогтоох байгууллагаар батлуулалгүй зарцуулдаг байна.

Аудитын дээд байгууллагын хяналт



Хангалттай

Аудитын дээд байгууллагын зүгээс төсөвт тавих хяналт **хангалттай** түвшинд байна. Хуулийн дагуу уг байгууллага нь тохиромжтой гэж үзсэн хэлбэрээр аудит хийх эрх мэдэлтэй байдаг. Түүнчлэн аудитын дээд байгууллагын удирдлагыг хууль тогтоох буюу шүүх засаглалын зөвшөөрөлгүйгээр өөрчлөх боломжгүй байдаг нь тус байгууллагын хараат бус байдлыг хангахад чухал ач холбогдолтой. Эцэст нь, аудитын дээд байгууллага өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах хангалттай нөөцтэй боловч чанарын баталгаажилтыг хангах тогтолцоо нь хязгаарлагдмал байна.

ЗӨВЛӨМЖ

Төсвийн ил тод байдлыг сайжруулах талаар

Төсвийн ил тод байдлыг сайжруулахын тулд Монгол Улс дараах арга хэмжээг нэн түрүүнд хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд:

- Хагас жилийн тойм, гүйцэтгэх засаглалын төсвийн төслийн иргэдэд зориулсан хувилбарыг боловсруулж, нийтлэх.
- Гүйцэтгэх засаглалын төсвийн төслийн иж бүрэн байдлыг нэмэгдүүлэх (ирэх жилүүдийн зарлагын чиг үүргийн ангилал болон макро эдийн засгийн таамаглалын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх).
- Жилийн эцсийн тайлангийн иж бүрэн байдлыг нэмэгдүүлэх (төлөвлөгөө болон гүйцэтгэлийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэх).

Иргэдийн оролцоог сайжруулах талаар

Төсвийн үйл явцад иргэдийн оролцоог сайжруулахын тулд дараах арга хэмжээг нэн түрүүнд хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд:

- Төсөвтэй холбоотой асуудлаар иргэдийн санал бодлыг авах итгэл хүлээсэн, үр дүнтэй механизм (жишээ нь: нийтийн сонсгол, судалгаа, зорилтот бүлгийн ярилцлага) бүрдүүлэх.
- Хууль тогтоох байгууллагын зүгээс тодорхой яам, газар, агентлагийн төсвийн талаарх сонсголыг зохион байгуулж, энэ үеэр иргэдийн нотлох мэдүүлгийг сонсох.
- Аудитын шалгалтад иргэдийн оролцоог хангах албан ёсны механизм бүрдүүлэх.

Төсөвт тавих хяналтыг сайжруулах талаар

Төсвийн хяналтыг сайжруулахын тулд дараах арга хэмжээг нэн түрүүнд хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд:

- Төлөвлөснөөс илүү орлогыг шилжүүлэн ашиглах, нөөц сангийн хөрөнгийг зарцуулахдаа хууль тогтоох байгууллагаар батлуулдаг болох.
- Хууль тогтоох байгууллагын зүгээс аудитын тайланг хэлэлцэх иргэдийн цуврал уулзалт зохион байгуулах.

АРГАЧЛАЛ

Төсвийн нээлттэй байдлын судалгаанд Олон улсын валютын сан, Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллага, Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага зэрэг олон талт хамтын ажиллагааны байгууллагуудаас боловсруулан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шалгуурыг ашигладаг. Энэ нь бодит байдлыг үнэлэхдээ ажиглахад хялбар мэдээлэл, эх сурвалжуудыг ашигладаг, баримтад тулгуурласан судалгааны хэрэгсэл юм. Судалгааг 2014 оны 3 дугаар сараас 2015 оны 9 дүгээр сар хүртэл нийт 18 сарын хугацаанд 102 улс орны 300 орчим шинжээчийг оролцуулан хийж гүйцэтгэсэн болно. Судалгаанд тэргүүн туршлагатай холбоотой гарч буй өөрчлөлтийг тусгах, судалгааны асуултуудыг боловсронгуй болгох зорилгоор аргачлалыг 2012 онохоос тодорхой хэмжээгээр өөрчилсөн болно. Энэхүү өөрчлөлтийн талаарх дэлгэрэнгүй тайлбарыг Төсвийн нээлттэй байдлын индексийг он оноор харьцуулсан аргазүйн танилцуулгаас үзнэ үү (www.openbudgetsurvey.org).

Судалгааны дүгнэлтийг ихэнх тохиолдолд эх сурвалж, саналаар баталгаажуулсан ба үүнд нийтэд ил тод болсон баримт бичгийн эшлэл, засгийн газрын албан ёсны мэдэгдэл, төрийн албан хаагч буюу бусад мэдээлэл бүхий этгээдтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлд үндэслэсэн болно.

Засгийн газарт хамаарахгүй, хараат бус төсвийн шинжээчдийн улс орон бүрээр бөглөсөн асуулгыг нэгтгэж судалгааны үр дүнг гаргасан. Дараа нь улс орон бүрийн асуулгыг мөн тухайн улсын Засгийн газартай холбоогүй, нэрийг нь дурдаагүй хөндлөнгийн шинжээчээр дахин хянуулсан болно. Түүнчлэн Олон улсын төсвийн түншлэл байгууллага (IBP) судалгааны урьдчилсан дүнгийн талаар саналаа өгөхийг Засгийн газруудаас хүсч, судалгааны дүнг эцсийн байдлаар гаргахаас өмнө дээрх саналуудыг авч үзсэн.

Олон улсын төсвийн түншлэл байгууллага нь Монгол Улсын Засгийн газраас Төсвийн нээлттэй байдлын судалгааны урьдчилсан дүнд санал авахаар хэд хэдэн удаа оролдлого гаргасан боловч санал авч чадаагүй болно.

Монгол Улсын Төсвийн нээлттэй байдлын судалгааны ажлыг Даваахүүгийн Оюунбадам гүйцэтгэв.

Хаяг: Нээлттэй Нийгэм Форум

Жамъян гүний гудамж – 5/1, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14240, Монгол Улс

Э-шуудан: osf@forum.mn, Утас: 313207

Нэмэлт мэдээлэл

www.openbudgetsurvey.org вэб хуудаснаас дараах нэмэлт мэдээллийг авна уу. Үүнд:

- Төсвийн нээлттэй байдлын судалгаа 2015: Дэлхийн тайлан
- Судалгаанд хамрагдсан 102 улсын мэдээллийн сан
- Төсвийн нээлттэй байдлын индексийг он оноор харьцуулах тухай аргазүйн танилцуулга